

ХОВД АЙМАГ БОЛОН МОЭНКО ХХК ХООРОНДЫН ХАМТРАН АЖИЛЛАХ ГЭРЭЭ

Хамтран ажиллах тухай энэхүү гэрээг /цаашид “гэрээ” гэх/ нэг талаас Ховд аймаг, түүнийг төлөөлж тус аймгийн Засаг дарга Б.Дүгэржав (цаашид “Ховд аймаг” гэх), нөгөө талаас МоЭнКо ХХК, түүнийг төлөөлж Дэд захирал Ж.Оюунчимэг нар (цаашид “Компани” гэх), (хамтад нь “Талууд” гэх) 2021 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр байгуулав.

ТАЛУУД ЭНЭХҮҮ ГЭРЭЭГ БАЙГУУЛАХДАА:

МоЭнКо ХХК нь Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн нүүрсний ордод ашигт малтмалын ашиглалтын Тусгай зөвшөөрөл эзэмшигч бөгөөд Хөшөөт төслийн (Төсөл) Хөрөнгө оруулагч мөн болохыг дурьдаж;

Талууд нь Төслийг амжилттай хэрэгжүүлэхэд бүх талын хүчин чармайлт гаргаж, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх, уул уурхайн үйл ажиллагааг байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл багатайгаар явуулах, байгаль орчныг нөхөн сэргээх, Төслийн хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтын ажлыг үе шаттай хэрэгжүүлж, Ховд аймгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, орон нутагт ажлын байрыг нэмэгдүүлэх, бизнес эрхлэгчдийг дэмжих чиглэлээр ил тод, үр ашигтай хамтран ажиллах хүсэл эрмэлзлэлтэй байгааг тэмдэглэн;

Дараахь нөхцөлөөр харилцан тохирч байгуулав.

1. Нийтлэг үндэслэл

1.1 Энэ гэрээ нь нэг талаас төслийн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, нөгөө талаас хариуцлагатай уул уурхайг эрхэлж, орон нутгийн хөгжлийг дэмжих үндсэн зорилтыг хэрэгжүүлэхтэй холбоотой Талууд хоорондын харилцааг зохицуулна.

1.2 Энэ гэрээгээр зохицуулаагүй харилцааг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээнд заасны дагуу зохицуулна.

2. Нэр, томъёоны тодорхойлолт

Гэрээнд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурьдсан агуулгаар ойлгоно:

2.1 “Гэрээт талбай” гэж энэхүү гэрээний 6.1-д тодорхойлсон талбайг;

2.2 “Төсөл” гэж хууль тогтоомжийн дагуу олгогдсон тусгай зөвшөөрлийн дагуу МоЭнКо ХХК-иас Хөшөөтийн уурхайд ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай холбоотой үйл ажиллагаа, бүтээн байгуулалтыг;

2.3 “Уурхайн дэд бүтэц” гэж Хөшөөт Ярант чиглэлийн 311 км хатуу хучилттай зам, гүүрийн байгууламж, Булган боомт дахь нүүрсний тусгай гарц бүхий талбай, уурхайн дотоодын зам, талбай, суваг, хоолой, эрчим хүчний барилга байгууламж, харилцаа холбоо, ус, дулаан хангамжийн шугам, нүүрс баяжуулах, угаах үйлдвэр, Хөшөөт болон Үенч суман дахь гаалийн хяналтын талбай, уурхайн кемп, ажлын байр, нүүрс химийн лаборатори, засварын цех, тоосжилтоос



хамгаалах хашаа, үйлдвэрлэлийн зориулалт бүхий бусад барилга байгууламжийг;

2.4 “Үндсэн үйл ажиллагаа” гэж энэхүү гэрээний 9.1-д тодорхойлсон үйл ажиллагааг;

2.5 “Туслан гүйцэтгэгч” гэж Төслийн үндсэн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд гэрээгээр тодорхой ажил, үйлчилгээ үзүүлж буй иргэн, аж ахуйн нэгжийг;

2.6 “Нөлөөллийн сум” гэж Төслийн үйл ажиллагааны шууд нөлөөлөлд өртөж буй Дарви, Цэцэг, Үенч, Булган, Алтай сумдыг;

2.7 “Хамтын ажиллагааны хороо” (“Хороо” гэх) гэж гэрээний хэрэгжилтэнд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий энэ гэрээний 24.1-д заасан нэгжийг;

2.8 “Орон нутгийн аж ахуйн нэгж” гэж Ховд аймгийн Улсын бүртгэлийн болон Татварын хэлтэст бүртгэлтэй аж ахуйн нэгжийг;

2.9 “Гуравдагч этгээд” гэж талуудаас бусад эрх ашиг, сонирхол нь хөндөгдсөн иргэн, хуулийн этгээдийг,

2.10 “Экспортлосон нүүрс” гэж Хөшөөтийн уурхайгаас Булган-Такашикен болон бусад боомтоор БНХАУ болон бусад улс оронд экспортлосон нүүрсийг тус тус ойлгоно.

3. Хамтын ажиллагааны зарчим

Талууд хамтын ажиллагаандаа дараахь зарчмыг баримтална:

3.1 Мэдээллийн ил тод, нээлттэй байдлыг хангаж, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх

3.2 Гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар биелүүлэх

3.3 Оролцогч талууд бие биенийхээ хууль ёсны хүсэлт, шаардлагыг хуулийн хүрээнд шуурхай шийдвэрлэх

3.4 Талуудын тэгш, шударга оролцоог хангах, нийгмийн түншлэлийг хөгжүүлэх

3.5 Харилцан бие биеийнхээ хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэж, хуулийг дээдлэх.

4. Талуудын харилцаа

4.1 Ховд аймгийн хөгжлийн бодлогын нэгдмэл байдлыг хангах үүднээс Талууд хоорондын хамтын ажиллагааг энэ гэрээгээр, энэхүү гэрээгээр зохицуулагдаагүй харилцааг Монгол улсын хууль тогтоомж, Олон улсын гэрээ, конвенцид заасны дагуу зохицуулна.

4.2 Ховд аймаг нь Төслийн нөлөөллийн сумдын төлөөллийг гэрээ байгуулах, хэрэгжилтэнд хяналт тавих, дүгнэх хамтарсан ажлын хэсэгт болон Хамтын ажиллагааны хороонд оролцуулна.



4.3 Талууд энэхүү гэрээг Монгол улсын Засгийн газрын 2016 оны 179 дүгээр тогтоолоор баталсан орон нутагтай хамтран ажиллах загвар гэрээний агуулгад нийцүүлэн байгуулж, Ховд аймгийг төлөөлж аймгийн Засаг дарга, Дарви сумын Засаг дарга болон компанийн төлөөлөл гэрээг баталгаажуулан гарын үсэг зурна.

4.4 Компани нь орон нутгийн төр захиргааны болон олон нийтийн байгууллагуудтай энэ гэрээ болон холбогдох хууль тогтоомжийн хүрээнд хамтран ажиллана.

5. Гэрээний хугацаа

5.1 Энэ гэрээ нь 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг хүртэлх 3 жилийн хугацаагаар байгуулав.

5.2 Талууд гэрээний хугацааг дуусахаас 30 хоногийн өмнө гэрээг цаашид шинэчлэн байгуулах асуудлаар хэлэлцэн тохирно.

6. Гэрээт талбай

6.1 Ашигт малтмалын ашиглалтын үйл ажиллагаа явуулахтай нь холбогдуулан МоЭнКо ХХК-д эрх бүхий байгууллагаас олгосон дараахь талбай нь гэрээт талбайд хамаарна.

6.1.1 Ашигт малтмалын газраас Ховд аймгийн Дарви сумын нутагт орших Хөшөөтийн орд газарт ашигт малтмал ашиглах зориулалтаар олгосон 4322А, 1414А, 11888А, 11887А, 020299А, 15289А, 6525А, 1640А тоот тусгай зөвшөөрөл бүхий, энэхүү гэрээний хавсралт 1-д заасан координат бүхий талбай;

6.1.2 Дарви сумын Засаг даргын 2010 оны 73 тоот захирамжаар үйлдвэрлэлийн зориулалтаар олгосон 0005373 тоот газар ашиглах гэрчилгээ бүхий талбай;

6.1.3 Үенч сумын Засаг даргын 2017 оны А/59 тоот захирамжаар Гаалийн хяналтын бүсийн зориулалтаар олгосон 0003445011 тоот газар ашиглах гэрчилгээ бүхий талбай;

6.2 Ховд аймаг болон тухайн сумын зүгээс гэрээт талбайд гуравдагч этгээдэд аливаа зориулалтаар давхардуулан газар олгохгүй. Хэрэв Газрын тухай хууль болон энэ гэрээг зөрчиж, гэрээт талбайд давхардуулан газар олгосон бол уг шийдвэрийг хүчингүй болгох ба үүнээс үүдэх үр дагаврыг Аймаг дангаар хариуцна.

7. Компанийн нийтлэг эрх, үүрэг

Компани дараахь нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

7.1 Тусгай зөвшөөрөл бүхий талбайгаас ашигт малтмал хайх, нүүрс олборлох, түүний ашигт агуулгыг нэмэгдүүлэх, баяжуулах, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, тээвэрлэх, борлуулах болон эдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг хууль тогтоомжид заасны дагуу хэрэгжүүлэх;

7.2 Үйлдвэрлэлийн шаардлагатай дэд бүтэц, барилга байгууламж барих, орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах, үндэсний боловсон хүчнийг бэлтгэх, сургах;



7.3 Үндсэн үйл ажиллагааг хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар явуулах;

7.4 Байгаль орчны нарийвчилсан үнэлгээгээр тодорхойлсон төлөвлөгөөний дагуу үйлдвэр, уурхайн орчин, замын маршрутын дагуу хөрс, ургамал, булаг шанд, гол горхи, ан амьтан, түүхийн дурсгалт газар/хиргисүүр, хөшөө, хадны зураг/хамгаалах ажлыг зохион байгуулж, нөхөн сэргээлт хийх, биологийн олон янз байдлын дүйцүүлэн хамгаалах ажлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу цаг хугацаанд нь хийж гүйцэтгэх;

7.5 Улсын болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татвар, төлбөр хураамжийг хуулийн хугацаанд төлөх;

7.6 Ховд Хөшөөт хөгжил санд энэ гэрээнд заасны дагуу төвлөрүүлж буй мөнгөн хөрөнгийг гэрээгээр хүлээсэн хугацаандаа төвлөрүүлэх ба Сангийн хөрөнгө оруулалтаар хийхээр төлөвлөж буй төсөл хөтөлбөрийн талаар Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хуралд санал хүргүүлэх, төслийн хэрэгжилтийн явцад хяналт тавих;

7.7 Төслийн бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээг энэ гэрээнд заасан нөхцөлөөр орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх;

7.8 Төслийн хүрээнд тухайн жилд орон нутгийн иргэд аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх бараа бүтээгдэхүүний ханган нийлүүлэлт, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, тоо хэмжээ, түүний чанар, тавигдах шаардлагын талаарх мэдээллийг өмнөх оны 12 дугаар сард багтаан нээлттэй мэдэгдэх.

7.9 Байгаль орчны менежмент төлөвлөгөөнд тусгагдсан ажил, арга хэмжээ, биологийн олон янз байдал болон байгаль орчны судалгаа шинжилгээний ажлыг гүйцэтгүүлэхдээ зохих шаардлага хангасан нөхцөлд тухайн орон нутагт бүртгэлтэй аж ахуйн нэгжид давуу эрх олгох;

7.10 Орон нутгийн төр, захиргааны байгууллагаас Төслийн дэд бүтцийг өргөтгөх, үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардагдах зөвшөөрөл, бусад дэмжлэг тусалцаа авах;

7.11 Байгаль орчныг хамгаалах, ажлын байр нэмэгдүүлэх, орон нутгийн хөгжил, боловсрол, эрүүл мэнд, нийгмийн хамгаалал, соёл, спорт, дэд бүтэц, жижиг дунд үйлдвэрлэл, инноваци, байгаль орчин, аялал жуулчлал, мал аж ахуй, газар тариалангийн салбарыг дэмжих чиглэлээр төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Ховд Хөшөөт хөгжил санд (ХХХС) энэ гэрээнд заасан нөхцөлөөр мөнгөн хөрөнгө төвлөрүүлж, хөтөлбөр арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавих;

7.12 Орон нутгийн иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын дотоодын нүүрсний хэрэгцээг хангах ажлыг Ховд аймагтай хамтран зохион байгуулах;

7.13 Нийгмийн хариуцлагын хүрээнд зорилтот бүлэг рүү хандсан дэмжлэг, тусалцааг сайн дурын үндсэн дээр үзүүлэх;

7.14 Төслийн хэрэгжилт, үйл ажиллагааны талаар олон нийтэд мэдээлэх,



сурталчлах ажлыг орон нутгийн засаг захиргаа, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж, үйл ажиллагааны талаарх танилцуулгыг хагас, бүтэн жилээр Аймагт хүргүүлэх;

7.15 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тайланг иргэд, олон нийтэд жилд нэг удаа мэдээлэх;

7.16 Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасан ажил олгогчийн эрх үүргээ бүрэн хэрэгжүүлж, ажилтнуудын эрүүл, аюулгүй орчинд ажиллах нөхцөлийг бүрдүүлэх;

7.17 Компани нь туслан гүйцэтгэгчтэй гэрээ байгуулахдаа холбогдох хууль тогтоомжоос гадна энэ гэрээг үндэслэл болгох;

7.18 Гэрээт талбайгаас олдсон археологи, антрапологийн ач холбогдол бүхий түүхийн үнэт олдвор, эд өлгийн зүйлс, соёлын үнэ цэнэтэй зүйлс олдсон тохиолдолд холбогдох газарт нэн даруй мэдэгдэж хуулийн дагуу шийдвэрлэх;

7.19 Компани Дарви сумаас уурхайд ажиллаж буй өөрийн ажилтнуудыг уурхайн кемпэд байрлуулж, 14 хоногийн давтамжтайгаар нэгдсэн унаагаар тээвэрлэх;

7.20 Уурхайн тоосжилтийн шууд нөлөөлөлд өртөж буй Дарви сумын Мөрөн баг, Цэцэг сумын Хажинга багийн малчдын өвөлжөө, хаваржааны судалгааг Аймаг (сум), Компани болон мэргэжлийн байгууллагын төлөөллийг оролцуулсан Ажлын хэсэг хамтран хийж, нөлөөлөлд өртөж буй малчин өрхийн тоог 2021.01.01-нээр тасалбар болгон эцэслэн гаргана. Тоосжилтын шууд нөлөөллийг их, дунд, бага 3 зэрэглэлээр тогтооно.

7.21 Тоосжилтонд ихээр өртөж буй малчин айл өрхийг хамтарсан Ажлын хэсэг нэн тэргүүнд нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авна. Энэ тохиолдолд Компани малчин өрхөд өвөлжөө, хаваржааны нөхөн төлбөрийг олгох ба Аймаг тухайн зориулалтаар шинээр газар олгох бөгөөд газрын байрлалыг сонгохдоо уурхайн нөлөөлөлд дахин өртөхгүй байх нөхцөлийг бүрдүүлнэ.

7.22 Уурхайн тоосжилтонд шууд өртөж буй нь Ажлын хэсгийн дүгнэлтээр тогтоогдсон, түүнчлэн нөлөөлөлд ихээр өртсөн боловч нүүн шилжихээс татгалзсан малчин өрхөд гэрээний хугацаанд жил бүр нөхөн олговор олгоно. Нөхөн олговрын хэмжээг нөлөөллийн зэрэглэлээс хамааруулан 1-3 сая төгрөгийн хязгаарт багтаан Ажлын хэсэг тогтоох ба тухайн жилд олгох нөхөн олговрын 50 хувийг Компани, 50 хувийг Аймаг хариуцан олгоно.

7.23 Жил бүр олгох нөхөн олговрыг нүүлгэн шилжүүлэлтэнд хамрагдсан малчин өрхөд давхардуулж олгохгүй бөгөөд тухайн сумын Засаг дарга нь нөлөөлөлд өртөж буй малчин өрхийн тоог цаашид нэмэгдүүлэхгүй байна.

7.24 Уурхайн үйл ажиллагаа 3 сар буюу түүнээс дээш хугацаанд зогссон тохиолдолд нөхөн олговрын хэмжээг уурхай зогссон хугацаанд хувь тэнцүүлэн бууруулж тооцно. Компаниас хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнд тоосжилтын нөлөөлөл буурсан бол нөхөн олговортой холбоотой энэ гэрээний заалтуудыг Талууд дахин хэлэлцэнэ.



7.25 Нүүрс тээврийн 311 км авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангахад байнгын хяналтын пост, үүрэг гүйцэтгэх алба хаагчдын ажиллах боломжийг хангахад зориулан авто машин, тоног төхөөрөмж, тусгай хэрэгсэл зэргийг Аймагтай хамтран шийдвэрлэх,

8. Ховд аймгийн нийтлэг эрх, үүрэг

Ховд аймаг дараахь нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

8.1 Төслийн үйл ажиллагааг тогтвортой, хэвийн явуулах, хөрөнгө оруулалтын таатай орчныг бүрдүүлэх ба хагас жил тутамд Төслийн мэдээллийг Засаг даргын зөвлөл, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн Хуралдаанаар сонсож, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

8.2 Иргэд, олон нийтэд төслийн үйл ажиллагааны талаарх үнэн, зөв, бодит мэдээллийг тогтмол хүргэж, шаардлагатай бол бодит бус мэдээллийг залруулах арга хэмжээ авах;

8.3 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг байгаль орчны үнэлгээ болон менежмент төлөвлөгөөний дагуу хийгдэж буй эсэхэд хяналт тавьж, хамтран ажиллах;

8.4 Үйлдвэр, уурхай, суурин түүний цахилгаан, дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээ байгуулах, гэрээт талбайд нүүрсний нөөц нэмэгдүүлэх, нарийвчилсан хайгуул судалгаа хийх, барилга байгууламжийн болон уурхай, үйлдвэрлэлийн хэрэгцээнд шаардлагатай газар олголт, ус хангамж зэрэг шаардлагатай зөвшөөрлийг хуулийн хүрээнд олгоно;

8.5 Орон нутгийн иргэдэд мэргэжил эзэмшүүлэх, ажлын байраар хангах асуудлыг талууд хамтран зохион байгуулах;

8.6 Компанийн зүгээс тавьсан санал, хүсэлтийг шуурхай хэлэлцэн шийдвэрлэх, шаардлагатай бол төрийн захиргааны байгууллагад уламжлан шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

8.7 ХХХС-нд гэрээний дагуу төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг энэ гэрээнд заасан зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, хяналт тавих, Сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн үр дүн, хэрэгжилтийн талаар олон нийтэд ил тод мэдээлж, Компанид улирал тутамд мэдээлэл ирүүлэх;

8.8 Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан баруун бүсийн сайжруулсан шахмал түлшний үйлдвэр байгуулах;

8.9 Гэрээг хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, Хамтын Ажиллагааны Хороог тогтвортой ажиллуулах;

8.10 Компанид хөрсний овоолго хийх газрын зөвшөөрлийг Дарви сум хуулийн хүрээнд олгох асуудлыг яаралтай шийдвэрлэх;

8.11 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй тээврийн болон уул уурхайн компаниудад нэг зарчмаар, шударга, ижил тэгш хандах, тэгш боломж олгох, тэдгээрт тавих хяналт, шаардлага, гэрээний нөхцлүүдийг ижил байлгана. Хэрэв шударга бус байдал үүссэн гэж үзвэл энэ гэрээний нөхцөл, компанийн хүлээсэн үүрэгт зохих өөрчлөлт оруулна;



8.12 Компанийн хөрөнгө оруулалтаар барьсан 311 км авто зам болон авто зам эзэмшигчийн эрхийг хуулийн хүрээнд хамгаалах, шаардлагатай дэмжлэг үзүүлэх;

8.13 Гэрээний хэрэгжилтийн явцад мэргэжлийн болон иргэний нийгмийн байгууллагаар хяналт хийлгэх ажлыг зохион байгуулах;

8.14 Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачлагын тайланг иргэдэд мэдээлэх ажлыг орон нутгийн дэд зөвлөлтэй хамтран зохион байгуулах;

8.15 Компанийн зарласан ажлын байр болон бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбогдсон мэдээллийг орон нутгийн иргэд, байгууллагад хүргэж, ил тод, нээлттэй хэлбэрээр сонгон шалгаруулалтанд оролцох боломжийг бүрдүүлэх.

8.16. Энэ гэрээний 7.22-т заасан малчин өрхөд жил бүр олгох нөхөн олговрын 50 хувийг олгоно.

9. Үндсэн үйл ажиллагаа

9.1 Энэхүү Гэрээ нь Гэрээт талбайд ашигт малтмал эрэх, хайх, газрын гадаргуу болон түүний хэвлийгээс ашигт малтмал олборлох, тээвэрлэх, эрчим хүч, усны болон бусад дэд бүтцийг барьж байгуулах, тэдгээрийг ажиллуулах, нүүрс боловсруулах (хуурай аргаар баяжуулах, угаах, бутлах, шигших гэх мэт) бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах, байгаль орчны нөхөн сэргээлт, дүйцүүлэн хамгаалал хийх, хөрс, нүүрсний овоолго, хог, хаягдлын менежмент болон Төслийн хэрэгжүүлэхтэй холбоотой бүх шатны үйл ажиллагаанд хамаарна.

9.2 Үндсэн үйл ажиллагааг саадгүй явуулахад нутгийн захиргааны болон мэргэжлийн байгууллагуудын зүгээс шаардлагатай дэмжлэг туслалцааг үзүүлж, хуулийн хүрээнд хамтарч ажиллана.

10. Татвар хураамж

10.1 Компани нь улс, орон нутгийн төсөвт төлөх албан татвар, төлбөр, хураамжийг хуулийн хугацаанд төлнө.

10.2 Ховд аймаг нь төлбөр хураамжийн хэмжээг үл ялгаварлах зарчмаар тогтооно. Төслийн үйл ажиллагааны хүрээнд Компани болон түүний туслан гүйцэтгэгчид ногдуулж буй төлбөр, хураамжийн хувь хэмжээ, шаардлага нь тухайн нутаг дэвсгэрт ижил төрлийн үйл ажиллагаа явуулж буй бусад аж ахуйн нэгжид ноогдуулж буй төлбөр, хураамжаас илүү хэмжээгээр тогтоогдсон бол Ховд аймаг түүнийг залруулах арга хэмжээ авна.

10.3 Хуульд харшлахааргүй бол нүүрсний гарал үүслийн гэрчилгээг Ховд аймаг дахь Худалдаа аж үйлдвэрийн танхимаас авна.

11. Байгаль орчин, усны хэрэглээ, газрын харилцаа

11.1 Компани нь байгаль орчныг хамгаалах талаар Ашигт малтмалын тухай хуулийн 35, 37 дугаар зүйлийн биелэлтийг хангаж ажиллана.



11.2 Компани хөрсний бохирдлыг зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтрүүлэхгүй байх, үйл ажиллагааны нөлөөллөөр эвдэгдсэн талбайг цаашид нийтийн хэрэгцээний зориулалтаар ашиглаж болохуйц байдлаар нөхөн сэргээж, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг авна.

11.3 Ховд аймаг нь Төслийг хэрэгжүүлэхэд шаардагдах цахилгаан эрчим хүч үйлдвэрлэх, эрчим хүчний болон бусад барилга байгууламж барих, ус, суваг татах, үйлдвэр барих, өргөтгөх, нүүрс ачих буулгах талбай байгуулах, хөрсний болон нүүрсний овоолго үүсгэх, газар ашиглах болон ус ашиглах зөвшөөрлийг хуулийн хүрээнд саадгүй олгоно.

11.4 Компани уурхайг ашиглах хугацаанд усны нөөцийг зохистой ашиглах зорилгоор үйлдвэрлэлийн хэрэгцээндээ аль болох гадаргын болон уурхайн шүүрлийн, цас, борооны усыг хуримтлуулан ашиглах ба гэрээний хугацаанд шинээр нүүрс угаах үйлдвэр барих тохиолдолд усыг дахин ашиглах технологийг нэвтрүүлнэ.

11.5 Компани байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөө, биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээг батлагдсан төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлж, энэ тухай тайланг жил тутамд Ховд аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар, АЗДТГ, Мэргэжлийн хяналтын газарт хүргүүлнэ.

11.6 Хөшөөт багийн төвийг шинэ байршилд нүүлгэн шилжүүлсэнтэй холбогдуулан нүүлгэн шилжүүлэх гэрээний биелэлт хангагдсан иргэдэд өмнө нь олгогдсон газрын гэрчилгээг Ховд аймаг 2021 оны 4-р улиралд багтаан хүчингүй болгоно.

11.7 Нөхөн олговор олгосон болон гэрээгээр чөлөөлсөн газарт дахин газар олгохгүй бөгөөд энэ заалтыг зөрчсөнөөс үүсэх үр дагаврыг Ховд аймаг хариуцна.

11.8 Компани уурхайн тоосжилт, хөрсний бохирдлыг бууруулах арга хэмжээг үе шаттайгаар авч хэрэгжүүлэн, байгаль орчны сөрөг нөлөөллийг бууруулах зорилгоор нойтон баяжуулах үйлдвэр байгуулах асуудлыг гэрээний хугацаанд судална.

12. Дэд бүтэц

12.1 Компани энэ гэрээний Хавсралт 2-т заасан дэд бүтцийн байгууламжуудыг өөрийн хөрөнгөөр барьж байгуулсан нь Хөшөөт төслийг амжилттай хэрэгжүүлэхэд чиглэсэн томоохон бүтээн байгуулалт болохыг Талууд хүлээн зөвшөөрч, үүгээр баталгаажуулж байна.

12.2 Ховд аймаг нь Төслийн хөрөнгөөр баригдсан үйлдвэрлэлийн дэд бүтцийг Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн зүгээс зориулалтын дагуу ашиглах боломжийг бүрдүүлж, эзэмшигч, хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаална.

12.3 Төслийг амжилттай хэрэгжүүлэх зорилгоор төвийн эрчим хүчний системд шинээр холбогдох, хүчин чадлыг нэмэгдүүлэх, энэ чиглэлээр эрх, зөвшөөрөл авах, цахилгаан дамжуулах агаарын шугам, дэдстанц, эрчим хүчний



барилга байгууламж барихад Ховд аймаг дэмжлэг үзүүлнэ.

12.4 Ховд аймаг нь Булган боомтын нэвтрэх хүчин чадал болон нүүрсний экспортыг нэмэгдүүлэх, тээвэрлэлтийг саадгүй явуулах чиглэлээр хоёр улсын эрх бүхий байгууллагуудтай хамтран ажиллаж, Төслийн үйл ажиллагаанд идэвхтэй дэмжлэг үзүүлэхийн зэрэгцээ Хөшөөтийн уурхайгаас Байтаг-Улиастайн боомт чиглэлд нүүрс экспортлохыг дэмжиж ажиллана.

12.5 Компани нь өөрийн хөрөнгөөр дараах дэд бүтцийн ажлуудыг гэрээний хугацаанд хийж гүйцэтгэнэ.

А. Хөшөөт дэх Гаалийн хяналтын бүсийн хучилтын талбайг хатуу хучилттай болгох;

Б. Автозам дагуу Цэцэг сумын Хажинга багт зам чөлөөлөх зогсоол барих;

В. Автозам дагуу Барлагийн хавцалд зам чөлөөлөх зогсоол барих;

Г. Хөшөөт багийг Цэцэг сумын авто замтай холбох 1,5 км хатуу хучилттай зам барих.

Д. Ховд аймгийн Жаргалант суман дахь өөрийн нэрэмжит гудамжны тохижилтийг сайжруулах.

13. Авто замын ашиглалт

13.1 Компани Хөшөөт-Ярант чиглэлийн 311 км хатуу хучилттай авто замын (цаашид "авто зам" гэх) хууль ёсны эзэмшигч бөгөөд уг замыг Төслийн үйл ажиллагаанд зориулан ашиглана. Төслийн үйл ажиллагаанд саад учруулахааргүй бол зорчигч тээврийн зорилгоор орон нутгийн иргэд, байгууллага замын хөдөлгөөний аюулгүй байдлаа хангаж зорчино.

13.2 Компанийн зөвшөөрөлгүйгээр уг замыг бизнесийн зорилгоор ашиглахыг хориглоно. Замыг бусад этгээдэд бизнесийн зорилгоор ашиглуулах тохиолдолд урьдчилан зөвшөөрөл авсан байх шаардлагатай бөгөөд зам ашиглуулах нөхцөл, журмыг Компани тогтооно. Авто зам эзэмшигчийн энэхүү эрхээ хэрэгжүүлэхэд нь Ховд аймаг зохих дэмжлэг үзүүлнэ.

13.3 Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангуулах асуудлыг хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд Ховд аймгийн Цагдаагийн газар, Автотээврийн төв хамтран зохион байгуулна.

13.4 Компани нь авто замын ашиглалтын байнгын бэлэн байдал, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангаж, авто замд тогтоосон журмын дагуу үзлэг хийж, арчлалт, засварын ажлыг тогтмол гүйцэтгэнэ.

14. Төслийн ажиллах хүч

14.1 Компани төслийн ажиллах хүчний 70-аас доошгүй хувийг орон нутгийн иргэдээс бүрдүүлнэ.

14.2 Компани нь орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, тэднийг сургалтанд хамруулах талаар орон нутгийн хөдөлмөрийн байгууллагатай хамтран ажиллаж, шаардлагатай ажлын байр болон түүнд тавигдах шаардлагыг ил тод, нээлттэй хэлбэрээр нийтэд зарлана.



14.3 Ховд аймаг нь Төслийн шугамаар гадаадаас ажиллах хүч авах, тэдгээрийг ажиллуулах асуудлаар хуулийн хүрээнд дэмжлэг үзүүлнэ.

14.4 Өөр орон нутгаас ажилтан, мэргэжилтэн урт хугацаагаар авч ажиллуулах тохиолдолд холбогдох хуулийн дагуу тухайн ажилтныг Засаг даргын Тамгын газарт бүртгүүлнэ.

15. Бараа, ажил үйлчилгээний худалдан авалт

15.1 Компани нь төсөлд бараа бүтээгдэхүүн нийлүүлэх, үйлчилгээ үзүүлэх боломж бүхий орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг дэмжиж, цаашид төслөөс хамааралгүйгээр үйл ажиллагаагаа бие даан явуулах боломжийг нь нэмэгдүүлэхэд чиглэсэн төсөл, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.

15.2 Компани болон Аймгийн зүгээс орон нутгийн аж ахуйн нэгжүүдийн бараа, ажил үйлчилгээний чанар стандартыг сайжруулах, үйл ажиллагааны чадавхийг нэмэгдүүлэх зорилгоор зөвлөмж, техникийн туслалцаа үзүүлэх замаар жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх чиглэлээр хамтарч ажиллана.

15.3 Төслийн хэрэгцээнд бараа, ажил үйлчилгээг худалдан авахад тавигдах шаардлагыг ижил нөхцлөөр хангаж буй орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн, хуулийн этгээдэд давуу эрх олгоно.

15.4 Төслийн хэрэгцээнд шаардлагатай мах, сүү, хүнс, хүнсний ногоо, цэвэр ус, машин техникийн түрээс, ажлын хувцас, эрүүл мэнд, байгаль орчны үйлчилгээ болон орон нутгаас нийлүүлэх боломжтой бусад бараа, ажил үйлчилгээг зохих чанар, стандартын шаардлага хангасан нөхцөлд орон нутгийн иргэд, аж ахуйн нэгжүүдээр гүйцэтгүүлэх замаар жижиг дунд бизнесийг дэмжиж ажиллана.

16. Экспортын нүүрс тээвэрлэлт

16.1 Компани энэ зүйлд дор заагдсан нөхцлүүдээр Нүүрс тээврийн үйлчилгээг улс хоорондын байнгын ачаа тээвэрлэлт гүйцэтгэхэд тавигдах шаардлагыг бүрэн хангасан, Ховд аймагт бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдээр 100 хувь гүйцэтгүүлнэ. Тээвэрлэлт хийх аж ахуйн нэгжүүдийг Ховд аймгийн "Авто тээврийн төв" ТӨҮГ-аас бүртгэлжүүлнэ.

16.2 Дараахь нөхцөлд Компани хуульд заасан эрхээ хэрэгжүүлж, тээвэрлэлтийн үйл ажиллагааг бие даан зохион байгуулна. Үүнд:

- Тээврийн компаниуд, тэдгээрийн жолооч нарын зүгээс экспортын тээвэрлэлтийг хууль бусаар 7 хоног буюу түүнээс дээш хугацаанд саатуулсан;
- Тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн тээврийн хэрэгслэлийн тоо хэмжээ нь экспортын шаардлагыг хангахгүй болсон;
- Тээвэрлэлтийн тонн/км-ийн үнийг гэрээнд заасны дагуу гэрээний талууд дахин авч хэлэлцэх нөхцөл бүрдээгүй байхад нэмэгдүүлэхээр тулган шаардалт хийж, тээвэрлэлтийг зогсоосон;

16.3 Эм И Си Транс ХХК нь орон нутгийн жолооч нарыг ажлын байраар хангаж буйн дээр Ховд аймагт бүртгэлтэй, татвар төлөгч аж ахуйн нэгжийн хувьд



тээвэрлэлтийн үйл ажиллагаагаа хэвийн явуулна. Аймаг, орон нутаг, жолооч тээвэрчид, үйлдвэрчний эвлэл, тээврийн компаниудын зүгээс Хөрөнгө оруулагчийн энэхүү эрхэд халдах, хууль бусаар хязгаарлахыг хориглоно.

16.4 Хэрэв орон нутгийн тээврийн хэрэгслэлүүдийн тоо хангалттай, тээврийн хэрэгслэлүүд нь эрх бүхий байгууллагаас тавигдаж буй байгаль орчны болон техникийн хувьд тавигдах шаардлагыг хангаж буй нөхцөлд Эм И Си Транс ХХК нь өөрийн тээврийн хэрэгслийн тоог 28-аас хэтрүүлэхгүйгээр тээвэрлэлт гүйцэтгэнэ. Гэрээний 16.2-т заасан нөхцөл байдал үүссэн, эрх бүхий байгууллагаас тусгайлан тавьсан шаардлагын хүрээнд тээвэрлэлтийг зохион байгуулах нөхцөлд энэ зүйлд заасан хязгаарлалт үйлчлэхгүй.

16.5 Эм И Си Транс ХХК-ийн тээвэрлэлтэнд оролцохдоо бусад аж ахуйн нэгжүүдтэй адил хуваарилалтаар оролцох бөгөөд давуу эрх эдлэхгүй байна.

16.6 Тээвэрлэлтийн гэрээний нөхцөл, тээвэрлэлтийн үнэ хөлсийг Авто тээврийн тухай хуульд заасны дагуу Компани болон тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцож тогтоох бөгөөд гэрээний талуудын чөлөөт байдалд бусад этгээдийн зүгээс хууль бусаар нөлөөлөх, дарамт шахалт үзүүлэхийг хориглоно.

16.7 Гэрээт аж ахуйн нэгжүүдийн зүгээс гэрээний үнэ, бусад нөхцөлтэй холбогдуулан санал гаргасан тохиолдолд талууд харилцан хэлэлцэж 30 хоногийн дотор зөвшилцөлд хүрнэ. Энэ хугацаанд Ховд аймгийн зүгээс Төслийн болон тээвэрлэлтийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангах арга хэмжээг авна.

16.8 Тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд нь өөрийн үйл ажиллагаандаа холбогдох хууль тогтоомж, төрийн эрх бүхий байгууллагаас баталсан дүрэм журам, стандарт шаардлагыг бүрэн хэрэгжүүлж, Төслийн үйл ажиллагааны тасралтгүй байдлыг хангахын зэрэгцээ өөрийн тээвэрчид, ажилтнуудыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах, хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангаж, тэдгээрийн ажиллаж, амрах таатай нөхцөлийг бүрдүүлэх үүрэгтэй. Үүнд энэ гэрээний Талууд болон жолооч тээвэрчдийн хууль ёсны эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллагын зүгээс хамтран хяналт тавьж ажиллана.

16.9 Тээвэрлэлтийн тонн/км-ийн үнийг тогтоохдоо эрх бүхий байгууллагаас тогтоосон жишиг тарифыг үндэслэн Компанийн санхүүгийн чадвар, ачааны зэрэг, ажил үйлчилгээний онцлог, замын нөхцөл, ачаа тээврийн эрэлт хэрэгцээ, түлшний үнийн хэлбэлзэл зэрэг тээвэрлэлтийн зардалд нөлөөлөх бусад хүчин зүйлүүдийг харгалзан тооцож, тээвэрлэлтийн гэрээний талууд харилцан тохиролцож тогтооно.

16.10 Компани нь тээвэрлэлтийн үйл ажиллагааг өөрийн тодорхойлсон менежментийн дагуу хараат бусаар бие даан зохион байгуулна.

16.11 Тээвэрлэлтийн гэрээний хэрэгжилтийг хангуулах, тээврийн жолооч нарын ажиллах таатай нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Компани, тээвэрлэгч аж ахуйн нэгжүүд болон тээврийн жолооч нарын эрх ашгийг төлөөлөн хамгаалах байгууллагын хооронд Хамтран ажиллах санамж бичгийг байгуулж, талууд хамтран ажиллана.

16.12 Компани уурхай эзэмшигчийн хувьд АТҮТ-тэй байгуулсан гэрээний үүргийн дагуу С зөвшөөрөл олгох тээврийн хэрэгслэлийн тоог өөрийн экспортын



төлөвлөгөө, хэрэгцээ шаардлагад нийцүүлэн улирал бүр АТҮТ-д гаргаж өгнө. Тээврийн хэрэгслэлүүдийн тоо хэмжээ хангалттай байгаа нөхцөлд С зөвшөөрлийн тоог нэмэгдүүлэхгүй бөгөөд гагцхүү тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн парк шинэчлэлтийг дэмжих зорилгоор сүүлийн 3 жилд үйлдвэрлэсэн тээврийн хэрэгслэлд С зөвшөөрлийг нэмж олгоно.

17. Орон нутгийн хөгжлийг дэмжих

17.1 Компани сайн дурын үндсэн дээр Ховд Хөшөөт Хөгжил Санд (ХХХС) экспортлосон нүүрсний тонн тутмаас мөнгөн хөрөнгө төвлөрүүлэх замаар орон нутгийн нийгэм, эдийн засгийн хөгжилд дэмжлэг үзүүлнэ. Үүнд, тухайн жилд экспортлосон нүүрсний тонн тутмаас гэрээний хугацаанд 1 ам. долларыг төвлөрүүлэх ба тухайн жилд 2 сая тонноос дээш экспортлосон нүүрсний тонн тутмаас 1,2 ам.долларыг төвлөрүүлнэ.

17.2 Компани ХХХС-д төвлөрүүлэх нийт мөнгөн хөрөнгийн 70 хувийг Ховд аймгийн хөгжлийн санд, үлдэх 30 хувийг (тус бүр 15 хувийг) Дарви, Цэцэг сумын хөгжлийн санд төвлөрүүлнэ.

17.3 Гэрээний 17.1 дэх хэсэгт заасан тонн тутмаас ХХХСанд төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн тооцно.

17.4 Мөнгөн хөрөнгийг улирлаар тооцож олгох бөгөөд тухайн улирал дууссанаас хойш 20 хоногийн дотор шилжүүлнэ. Мөнгөн хөрөнгийн дүн нь бодитоор экспортлосон нүүрсний хэмжээнд үндэслэнэ. Экспортлосон нүүрсний хэмжээг гаалийн газрын мэдээнд үндэслэх бөгөөд талууд сар бүрийн эцсээр тооцоо нийлж, баталгаажуулна.

17.5 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас нүүрсний экспорт дараалсан 30 өдөр буюу түүнээс дээш хугацаанд зогссон тохиолдолд Компани нүүрсний экспорт сэргэсэн өдрөөс хойш 15 хоногийн хугацаанд ХХХСанд төвлөрүүлэх хандиваас чөлөөлөгдөнө.

17.6 Давагдашгүй хүчин зүйлийн улмаас нүүрсний экспорт дараалсан 60 өдөр буюу түүнээс дээш хугацаанд зогссон тохиолдолд энэ гэрээний 17.1-д заасан мөнгөнхандивын тогтсон дүн хүчингүй болох бөгөөд Талууд гэрээний нөхцөлийг дахин хэлэлцэнэ.

17.7 Ховд аймаг нь ХХХС-ийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах бөгөөд зарцуулалтын дэлгэрэнгүй тайланг Ховд Хөшөөт Хөгжил Сангаас тухайн жилийн 12 дугаар сард багтаан Компанид албан ёсоор ирүүлж, тайланг өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд, ил тод мэдээлнэ. Сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлж буй төсөл, арга хэмжээний талаарх мэдээллийг Ховд аймаг, ХХХСангийн зүгээс олон нийтэд тогтмол хүргэж, сурталчлах ажлыг зохион байгуулна.

17.8 Компани тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, бие даан хөгжих чадавхийг нь нэмэгдүүлэх, байгаль орчныг дүйцүүлэн хамгаалах чиглэлээр зорилтот төсөл хөтөлбөрийг гэрээний хугацаанд хэрэгжүүлнэ.

17.9 Компани үйл ажиллагааны тогтвортой байдал, санхүүгийн боломждоо тулгуурлан тухайн жилд хэрэгжүүлэх тогтвортой хөгжлийг дэмжих төсөл,



хөтөлбөрийн чиглэл, төлөвлөгөөг боловсруулж, жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан төсөл сонгон шалгаруулах арга хэмжээг ил тод, нээлттэй хэлбэрээр зохион байгуулна. Уг төслийн хэрэгжилтийн явц, үр дүнг нийтэд мэдээлнэ.

17.10 Компани нийгмийн хариуцлагын хүрээнд дотоодын их дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд тэргүүлэх чиглэлээр суралцах 50 хүртэлх оюутанд сургалтын төлбөрийн дэмжлэг үзүүлэх ажлыг орон нутагтай хамтран хэрэгжүүлнэ.

17.11 Компани уг гэрээнд зааснаас бусдаар улс төрийн нам, төрийн байгууллага, албан тушаалтнаас ирүүлсэн хандив, тусламжийн хүсэлтийг хүлээн авахаас татгалзана.

18. Орон нутгийн хэрэгцээний нүүрс

18.1 Орон нутгийн иргэд, байгууллагын хэрэгцээнд нүүрс нийлүүлэх ажлыг Компани нь Аймаг болон бусад уурхай эзэмшигчтэй тэгш оролцоотойгоор хамтран зохион байгуулах бөгөөд жил бүрийн 9 дүгээр сарын 15-наас дараа жилийн 3 дугаар сарын 1-ний хооронд гэрээнд заасан үнээр саадгүй нийлүүлнэ. Уг хугацаа нь Аймагийн дулааны станцыг нунтаг нүүрсээр хангахад хамааралгүй болно.

18.2 Компани нийгмийн хариуцлагын хүрээнд сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлийг дэмжиж, эхний ээлжийн 100,000 тонн хүртэлх эрчим хүчний нунтаг нүүрсийг үнэ төлбөргүй нийлүүлэх бөгөөд цаашид нийлүүлэх нүүрсний үнэ, бусад нөхцөлийг тусдаа гэрээгээр зохицуулна.

18.3 Компани нэг тонн бүхэл нүүрсийг гэрээний хугацаанд Ховд аймгийн иргэдэд 25,000 төгрөгөөр, төрийн байгууллага, аж ахуйн нэгжид 60,000 төгрөгөөр, эрчим хүчний нунтаг нүүрсийг 10,000 төгрөгөөр нийлүүлнэ. Уурхайн нүүрсний бүхэллэг чанар алдагдаж, гарц багасч байгаагаас шалтгаалан гэрээний дагуу тухайн жилд нийлүүлэх бүхэл нүүрсний хэмжээг өмнөх онуудын дундаж хэмжээнээс хэтрүүлэхгүйгээр Талууд харилцан тохирч тогтооно.

18.4 Нөлөөллийн бус 6 сумдын хэрэгцээнд жил тус бүр 300 хүртэлх тонн бүхэл нүүрсийг жил бүрийн 8 дугаар сарын 15-наас 9 сарын 15-ны хооронд нийлүүлнэ.

18.5 Иргэд, олон нийтийн байгууллагын хууль бус үйл ажиллагаа, шаардлага, төр захиргааны байгууллагын шийдвэрээр энэ гэрээний 18.1-д заасан хугацаанд уурхайн хэвийн үйл ажиллагаа 7 хоног буюу түүнээс дээш хугацаанд тасалдах, зогсох тохиолдолд Компани энэ Гэрээний 18.1- 18.3-т заасан үүрэг хүлээхгүй.

18.6 Хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж байгууллагууд нүүрсний үнийг цаг тухайд нь компанид төлөх үүрэгтэй бөгөөд төлбөрөө төлөөгүй хэрэглэгчидтэй Компани гэрээ байгуулж хамтран ажиллахаас татгалзах эрхтэй.

19. Үйл ажиллагааны баталгаа

19.1 Хөрөнгө оруулагч, түүний хамааралтай этгээдийн Монгол Улсад оруулсан хөрөнгө оруулалт нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөрөнгө оруулалтын тухай хууль болон Монгол Улсын бусад хууль тогтоомж, олон улсын гэрээгээр баталгаажсан эрх зүйн бүрэн хамгаалалтад байна.



19.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч үйл ажиллагаагаа хэвийн, тасралтгүй явуулах, хууль ёсны эрхээ хэрэгжүүлэхэд орон нутгийн иргэн, хуулийн этгээд, төрийн бус байгууллагын зүгээс саад учруулсан, эсхүл төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагааны улмаас Төслийн үйл ажиллагаа саатсан тохиолдолд Компани уг асуудлыг шийдвэрлүүлэхээр Засаг дарга, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хандах бөгөөд Ховд аймаг хууль бус үйл ажиллагааг нэн даруй таслан зогсоох үүрэгтэй.

19.3 Ховд аймаг хууль бус үйл ажиллагааг таслан зогсоох арга хэмжээг зохих ёсоор аваагүйгээс Төслийн үйл ажиллагаа тухайн сард хуримтлагдсан 7 хоног буюу түүнээс дээш хугацаанд саатсан бол Компани тухайн сард ХХХСанд төвлөрүүлвэл зохих мөнгөн хөрөнгийг, хуримтлагдсан 14 хоног буюу түүнээс дээш хугацаанд саатсан бол тухайн улиралд ноогдох мөнгөн хөрөнгийг, хуримтлагдсан 30 хоног буюу түүнээс дээш хугацаанд саатсан бол тухайн жилд ноогдох мөнгөн хөрөнгийг төвлөрүүлэх үүрэг хүлээхгүй.

19.4 Компани гуравдагч этгээдийн хууль бус үйл ажиллагааны улмаас өөрт учирсан хохирлыг буруутай этгээдээр нөхөн төлүүлэхээс гадна тодорхой хувь хүн, хуулийн этгээдийг Төслийн үйл ажиллагаанд цаашид оролцуулахгүй байх эрхтэй.

19.5 Энэ гэрээний 19.2-т заасан “хууль бус үйл ажиллагаа”-нд иргэдийн зүгээс Үндсэн хуулиар олгогдсон жам ёсны эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой, хуулийн дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан, компанийн үйл ажиллагааг аливаа хэлбэрээр саатуулаагүй хуулийн хүрээнд явуулж буй тайван жагсаал, цуглаан хамаарахгүй.

20. Маргаан шийдвэрлэх

20.1 Талууд Гэрээнээс үүдэлтэй үл ойлголцол, маргааныг эвийн журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

20.2 Гэрээг хэрэгжүүлэх, талуудын хооронд үүссэн маргаантай асуудлыг шийдвэрлүүлэхээр гэрээний нэг тал нь нөгөө талдаа бичгээр мэдэгдэл хүргүүлнэ. Мэдэгдлийг хүлээн авснаас хойш Хамтын ажиллагааны Хороо уг асуудлыг ажлын 5 өдөрт багтаан шуурхай хэлэлцэж, боломжит хувилбараар шийдвэрлэнэ.

20.3 Талууд тухайн асуудлаар 14 хоногийн хугацаанд аливаа шийдэлд хүрээгүй бол маргаж буй асуудлаар мэргэшсэн, хараат бус, хөндлөнгийн Зуучлагчийг санал нэгтгэйгээр томилно.

20.4 Гэрээний 20.3-т заасан Зуучлагч нь маргааныг 14 хоногийн дотор зохицуулж чадаагүй бол Талууд маргааныг Монголын Үндэсний Арбитрийн шүүхэд хандан шийдвэрлүүлнэ.

20.5 Гэрээтэй холбоотой тодорхой асуудлаар маргаан үүссэн нь Талууд гэрээний бусад заалтыг хэрэгжүүлэхгүй байх үндэслэл болохгүй.

21. Гэрээг зөрчсөнөөс үүсэх үр дагавар

21.1 Гэрээний аль нэг тал нь гэрээг зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс нөгөө талд эдийн засгийн хувьд ноцтой нөлөө үзүүлэхүйц бодит



хор уршиг учруулсан бол гэрээг цуцлах үндэслэл болно.

21.2 Энэ гэрээний 21.1-д дурьдсанаас бусад тохиолдолд Гэрээний нэг тал нь шаардлагатай бол гэрээний зөрчлийг арилгуулахаар нөгөө талдаа мэдэгдэл хүргүүлэх бөгөөд мэдэгдэл хүлээж авсан тал нь 14 хоногийн дотор зөрчлийг арилгах үүрэгтэй.

21.3 Зөрчлийн үр дагаврыг арилгах боломжгүй болсон бол гэрээг зөрчсөн тал цаашид гарах үр дагавраас сэргийлэх арга хэмжээг авч, нөгөө Талдаа бичгээр мэдэгдэнэ. Гэрээг зөрчсөн, гэрээний үүргээ биелүүлээгүйгээс учирсан хохирлыг эрх нь зөрчигдсөн тал нэхэмжлэх эрхтэй.

22. Давагдашгүй хүчин зүйл

22.1 Гэрээний аль нэг тал нь давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллөөр гэрээний үүргээ хэрэгжүүлэх боломжгүй болсон бол нөгөө талдаа бичгээр мэдэгдэнэ. Ийнхүү мэдэгдэхдээ шалтгаан болон давагдашгүй хүчин зүйл арилах боломжит хугацааг мэдэгдэнэ.

22.2 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөлөлд өртсөн талын гэрээгээр хүлээсэн үүргийн хэрэгжилт энэ тохиолдолд түдгэлзэх ба энэ хугацаанд гарах аливаа хохирол, төлбөр, хариуцлагаас бүрэн чөлөөлөгдөнө.

22.3 Давагдашгүй хүчин зүйлийн нөлөөллийг талууд аль болох богино хугацаанд арилгахын тулд хамтран ажиллаж, шаардлагатай бүхий л арга хэмжээг авна.

22.4 Давагдашгүй хүчин зүйл гэдэгт нөлөөлөлд өртсөн талын хүсэл зоригоос үл шалтгаалах дараах хүчин зүйлүүд хамаарна. Үүнд:

- 1) Дайн, үймээн самуун, бослого хөдөлгөөн, бүслэлт хориглолт,
- 2) Хорио цээр, гал түймэр, газар хөдлөлт болон байгалийн гамшиг,
- 3) Төслийн үйл ажиллагааг саатуулах нөлөөлөл бүхий Монгол улс болон БНХАУ-ын төр, засгийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, иргэд, хуулийн этгээд, иргэний нийгмийн байгууллагын жагсаал, цуглаан, эсэргүүцлийн үйл ажиллагаа,
- 4) Аль нэг талын буруугаас шууд шалтгаалаагүй техник, тоног төхөөрөмжийн томоохон эвдрэл сүйрэл

23. Хууль тогтоомж өөрчлөгдөх

23.1 Монгол улсын хууль тогтоомж болон олон улсын гэрээ конвенцид өөрчлөлт орсон нь энэ гэрээг хэрэгжүүлэхэд сөргөөр нөлөөлөхөөр бол талууд тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ.

24. Хамтын ажиллагааны хороо



24.1 Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Хамтын ажиллагааны хороо (цаашид "Хороо" гэх)-г Засаг даргын Тамгын газар, тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн орон нутгийн иргэдийн төлөөллийг оролцуулан байгуулж ажиллуулна.

24.2 Хороо нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд талуудын оролцоог тэгш хангасан байна. Хорооны бүрэлдэхүүнд орох иргэдийн төлөөллийг Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас нэр дэвшүүлнэ. Хорооны бүрэлдэхүүнийг Ховд аймгийн Засаг дарга томилж, чөлөөлнө.

24.3 Хороо гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана. Хорооны ажиллах журмыг талууд хамтран батална.

25. Гэрээний хэрэгжилт, гэрээг дүгнэх

25.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор тухайн орон нутгийн иргэдэд гэрээ байгуулсан талаар мэдээлж, гэрээ, түүнтэй холбогдсон баримт бичгийг Талууд өөрийн цахим хуудсанд ажлын 3 хоногийн дотор байршуулна. Гэрээний хувийг ажлын 5 хоногийн дотор аймаг (сум, дүүрэг)-ийн Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын дэд зөвлөлд хүргүүлнэ.

25.2 Талууд гэрээний хэрэгжилтийг жил бүрийн 1-р сард багтаан Аймгийн Засаг даргын захирамжаар томилогдсон Ажлын хэсэг дүгнэж, үнэлэлт дүгнэлт өгөх ба гэрээний хэрэгжилтийн тайланг 2 дугаар сарын 1-ний дотор Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлнэ.

25.3 Гэрээний хэрэгжилтийг заалт нэг бүрээр, тодорхой оноогоор дүгнэх бөгөөд тухайн жилдээ 60 буюу түүнээс доош оноогоор дүгнэгдсэн бол хангалтгүй гэж үзнэ. Гэрээний хэрэгжилт хангалтгүй дүгнэгдсэн бол Талууд хэрэгжилтийг сайжруулахад чиглэсэн арга хэмжээг төлөвлөн, зохион байгуулна.

25.4 Талууд гэрээний тухайн жилийн хэрэгжилтийн тайланг дараа оны 2-р сарын 15-ны дотор дээд шатны Засаг дарга болон геологи, уул уурхайн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлнэ.

25.5 Гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай гэж үзвэл талууд бичгээр хүсэлт гаргах бөгөөд уг асуудлаар Хамтын ажиллагааны хороо хамтарсан хуралдаан зохион байгуулж, харилцан тохирсноор гэрээнд өөрчлөлт оруулж болно.



26. Бусад

26.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болно.

26.2 Хамтран ажиллах талаар талуудын хооронд (аймаг, сум, багийн түвшинд) өмнө нь байгуулагдсан аливаа гэрээ хэлцэл энэ гэрээ байгуулагдсанаар хүчингүйд тооцогдоно.

26.3 Гэрээг Монгол хэл дээр үйлдэж, хувийг талууд тус бүр хадгална.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

ХОВД АЙМГИЙГ ТӨЛӨӨЛЖ:
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА


Б.ДҮГЭРЖАВ

ДАРВИ СУМЫН ЗАСАГ ДАРГА


О.ГАНЦООЖ


МОНКО ХХК-Г ТӨЛӨӨЛЖ:
ДЭД ЗАХИРАЛ


Ж.ОЮУНЧИМЭГ

ТӨР, ОЛОН НИЙТТЭЙ
ХАРИЛЦАХ АСУУДАЛ
ЭРХЭЛСЭН ЗАХИРАЛ


Ж.ГӨЛГӨӨ

Ховд аймаг болон МоЭнКо хоорондын
Хамтран ажиллах гэрээний Хавсралт №1
МоЭнКо ХХКК-ийн ашиглалтын тусгай зөвшөөрлийн тайлбайн байршил



Handwritten signature

МОЭНКО ХХК-ИЙН ӨӨРИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХИЙГДСЭН ДЭД
БҮТЦИЙН БҮТЭЭН БАЙГУУЛАЛТУУДЫН ЖАГСААЛТ

1. Хөшөөт-Ярант чиглэлийн 311 км хатуу хучилттай автозам
2. Булган сумын төвд баригдсан 3 км хатуу хучилттай авто зам
3. Үенч сумын төвд баригдсан 1,8 км хатуу хучилттай авто зам
4. Нүүрсийг хуурай аргаар баяжуулах үйлдвэр (Хөшөөтийн уурхай)
5. Нүүрс угаах үйлдвэр (Такашикөний аж үйлдвэрийн парк)
6. Гаалийн хяналтын талбай (Хөшөөт)
7. Гаалийн хяналтын талбай (Үенч)
8. Булган боомт дахь нүүрсний тусгай гарцын талбай
9. Нүүрс химийн лаборатори (Хөшөөт)
10. Уурхайн оффис
11. Уурхайн ажилчдын кемп (кемпийн өргөтгөлүүд)
12. Хүнд машин механизмын засварын цех
13. Тоосжилтоос хамгаалах зориулалтын хашаа 1160 м (Хөшөөт)
14. Тоосжилтоос хамгаалах зориулалтын хашаа 1150 м (Үенч)
15. Авто пүүнүүд 4 ширхэг
16. Тоног төхөөрөмжийн агуулах
17. Нүүрсний агуулахууд
18. Орон нутгийн нүүрсний талбай
19. Цахилгаан, дулаан хангамж, шугам сүлжээ, гүний худаг